

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 03 дугаар сарын мэдээ

2022.03.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 19 албан бичиг ирсний 10 нь хариутай, 8 –нь хугацаандаа, 2–нь хугацаа болоогүй байна.

Сумын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, Сумын засаг дарга төсөвт байгууллагын дарга эрхлэгч, багийн засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ, тамгын газрын дарга мэргэжилтэн нартай гүйцэтгэлийн гэрээг байгууллаа.

Алдарт эхийн 1,2 дугаар одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг бүрдүүлж архивын нэгж үүсгэн аймгийн тамгын газарт хүргүүллээ.

Сумын засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/37 тоот захирамжаар сумын нутгийн удирдлагын ордоны зураг төсвийн ажлыг “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХКомпаниар, мөн Сумын засаг даргын 03 дугаар сарын 16-ны өдрийн А/38 тоот захирамжаар “Нэгдсэн хогийн цэг”-ийн зураг төсвийн ажлыг “Сити Лэнд” ХХКомпаниар тус тус гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж зургийн ажил хийгдэж байна.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Шилэн дансны цахим системд тухай бүр оруулах 8, сар бүр оруулах 3 мэдээлэл нийт 12 төрлийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан. Төрийн аудитын газраас ирсэн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн судалгаа үндсэн хөрөнгийн судалгааг хийж гүйцэтгэн хүргүүлсэн.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахимаар, 6 дугаар багийн иргэдэд цаг үеийн асуудлаар болон хог хаягдлын тухай хуулиар мэдээллийг танхимаар хүргэж ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: Биеийн тамирын багш Б.Даваажаргал жудо бөхийн өсвөр үе, насанд хүрэгчдийн ААШТэмцээнд баг бүрэлдэхүүнээрээ 2022 оны 02 сарын 24-нөөс 02 сарын 28-ны хооронд Сүхбаатар аймагт оролцон өсвөр үеийн хөвгүүд охидын төрөлд 1,2 дугаар байрыг эзэллээ.

Эх хэлний багш нар хамтран Ерөнхий Боловсролын сургуулийн багш, ажилчдад 14 хоногийн “Үндэсний бичиг” аяныг өрнүүллээ.

Зөвлөн туслах багш Лхагвацэрэн багш удирдах албан тушаалтан болон мэргэжлийн багш нартай уулзалт хийж, зөвлөн туслах, арга зүй, мэдлэгийг дээшлүүлэн “Хичээл гэж юу вэ” “Хичээлийн үе шат” “Хичээлийн хэлэлцүүлэг хэрхэн зохион байгуулах вэ” сэдэвт танхимын сургалтуудыг зохион явууллаа.

ЯХИС-аас санхүүжин хэрэгжиж буй “Хувь хүний ур чадвар, энтерпернершипийн боловсрол олгох төсөл” хөтөлбөрийн аймгийн зөвлөлийн гишүүд болон ЯХИС-ын Сүхбаатар аймаг дахь салбарын мэргэжилтэн нар 3 дугаар сарын 7-ны өдөр сумын ЕБСургууль дээр ажиллаа. Уг хөтөлбөрийн үеэр 2-р шатанд шалгарсан 4 төслийг хэлэлцэн улмаар 2 төсөл 3-р шатандаа шалгарлаа.

Сурагчдын холбооны 5 төрөлт сургалт \гитар, сэтгэл судлал, бүжиг, загвар, илтгэх урлаг\ 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 21-ны өдрийг хүртэл 5-11 дүгээр ангийн бүртгүүлсэн сурагчдын дунд зохион байгуулагдаж 03 сарын 21-ны өдөр “Соёлын төв”-д тайлан тоглолтоо хийж амжилттай өндөрлөлөө.

Соёл: Тухайн сард соёл урлагийн үйл ажиллагаа 12 удаа зохион байгуулж 1230 хүнийг хамруулж ажиллаа. Хурал зөвлөгөөн бусад арга хэмжээ 6 удаа зохион байгуулагдаж

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Баярлалаа ээжээ” баярын тоглолт мөн ахмад уран сайханчдын “Ардын дуугаараа алдаршъя” тоглолт, “Хүрээ хүүхнүүд”, “Бүсгүйчүүд” цэнгүүнийг тус тус зохион байгууллаа.

МУСТА Ч.Алтантүлхүүрийн “Малчин заяа” тоглолтыг хүлээн авч ард иргэдэд хүргэлээ.

Монгол улсад орчин цагийн зэвсэгт хүчин байгуулагдсаны 101 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Тэнгэрлэг эрчүүд”, Зэвсэгт хүчний 086-р тусгай роттой хамтран “Бид агаарын хилчид” хөтөлбөрт цэнгүүнийг тус тус зохион байгууллаа.

Соёлын төвийн номын сан нь ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож ажиллаж байна . 3 дугаар сард байнгын уншигч 32, ирэгсэд 183 иргэнд 148 ном гэрээр олгож 24 иргэнд утсаар болон амаар лавлагаа өгч 13 татгалзал бүртгэлээ.

АИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 75 тоот тогтоолоор батлагдсан “Судар эгшиглэн” дэд хөтөлбөрийн хүрээнд зарлагдсан Оны шилдэг уншигч шалгаруулах Судар эгшиглэн-2022 уралдааны болзлыг танилцуулан сумын уншигчдыг дэмжих сурталчилан танилцуулах хандлагыг өөрчлөх ном унших дадал хэвшилтэй болгох зорилгоор суманд 1,2-р шатыг зохион байгуулах удирдамж төлөвлөгөөг гарган ЕБС-ийн номын санчтай хамтран ажиллаж байна.

Судар эгшиглэн төслийн 1-р шатанд ЕБС-ийн 32 сурагч, насанд хүрэгсэд 17 оролцож Миний уншсан ном видео бичлэгийг Судар эгшиглэн -2022 групп болон соёлын төвийн группд байрлуулж сурталчилаа.

Судар эгшиглэн -2022 уралдааны 2-р шатанд оролцох хүүхдүүдэд зориулан номын тэмдэглэл хөтөлж сурхад нь туслах зорилгоор Уншсан номын тэмдэглэлийн дэвтэрийг захиалан авчирч заавар зөвлөмж өгч ажиллаа.

Төслийн 2-р шатанд уншигдах номын судалгааг хийж хэрэгцээт ном хэвлэлийг худалдан авах фондын баяжилтыг нэмэгдүүлэх ажлыг хийхээр төлөвлөөд байна.

Аймгийн нийтийн номын сангаас зохион байгуулсан номын санчдын спортын наадам, чадавхижуулах сургалт семинар, дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Яруу үдэш” шинэ шүлгийн уншлагын арга хэмжээнд яруу найрагч У.Буд, Б.Арьяа нарын хамт оролцлоо.

“Баяндэлгэр сум–Малчдын зөвлөгөөн” үйл ажиллагааг Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж малчдын дунд үдэшлэг цэнгүүнийг зохион байгууллаа.

Мөн 62-94 насны 7 ахмадад төрийн шагнал гардуулах ёслолын ажиллагааг ЗДТГ-тай хамтаран зохион байгууллаа.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Үдшийн цэнгүүн 5 удаа зохион байгууллаа.

Биеийн тамир спортын улсын хороо, Аймгийн засаг даргын 2022 оны А/96 дугаар захирамжийн дагуу зохион байгуулж байгаа “Илүүдэл жингүй – Эртэч

монгол” аяны хүрээнд байгууллага дээрээ өдөр бүр өглөөний дасгалыг хийж хэвшүүлээ.

2022 оныг “Тохижилт – Бүтээн байгуулалт”-ын жил болгон зарласантай холбогдуулан сумын нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах ил задгай хог хаягдалгүй байлгах орчны ариун цэврийг сайжруулах зорилготой хаврын бүх нийтийн цэвэрлэгээнд удирдамжинд заасны дагуу “Жишиг хороолол”-ын 6 гудамжинд оршин суух 135 айл өрхүүдийн цэвэрлэгээг хариуцан ажиллаа.

Цэцэрлэг: Энэ сард хүүхдийн ирц 163-188-ийн хооронд хэлбэлзлээ. Хүүхдийн дунд ханиад, томуу томуу төст өвчлөл гарч эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн болон гадуур стор нээн эмчлүүлсэн 11 хүүхэд байна. Үүнтэй холбоотой багш ажилчид ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж бэлтгэн байгууллагын цахим хаяг болон бүлгийн дотоод группээр дамжуулан хүргэхийн зэрэгцээ хэвлэмэл гарын авлага 505 ширхэгийг тарааж өгсөн. 9 бүлгийн 552 хүүхдэд цэцэрлэгийн эмч сургалт зохион байгуулсан. Мөн халдвар хамгааллыг баримтлан ариутгал халдваргүйтлийг 7 хоногт 2 удаа ангийн дотор агаар сэлгэлт ариутгалыг 2 цаг тутамд хийж хэвшээд байна.

Олон нийтийн цэвэрлэгээнд хамт олноороо оролцож өөрийн байгууллагын ойр орчин болон хариуцсан эцэг 5 малын хөшөөг цэвэрлэх мөн Орлой байрны 15 эгнээ 131 айл өрхийг хариуцан хогийг цэвэрлүүлж тайланг холбогдох газарт хүргүүлсэн.

Энэ сард ажлын байранд 4 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 124, Орон нутгийн 2 сургалтанд 12, Олон улсын Эко сургууль, цэцэрлэг хөтөлбөрт 5 албан хаагч тус тус хамрагдсан байна.

Ажлын байранд тасралтгүй багшаа хөгжүүлэх заах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор нээлттэй хичээлийг зохион байгуулж нийт 8 багш өөрийн заах ур чадвараа бусдадаа түгээн дэлгэрүүлсэн байна.

“Илүүдэл жингүй эртэч монгол” дасгал хөдөлгөөнд байгууллага хамт олноороо нэгдэж өглөө бүр ажлын байранд дасгал хөдөлгөөн хийж хэвшээд байна.

Эрүүл мэндийн төв: Тухайн сард 544 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж – 178 иргэн больницод хэвтэн эмчлүүлсний 32 нь хүүхэд, кронавируст халдвартай – 18 иргэн байна. Алсын дуудлага – 27 ирсэнийг дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Сэргээн засах эмчилгээний кабинетаар 71, лабораториор 348 иргэн тус тус үйлчлүүлээ.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” сарын аяныг зохион байгуулж 252 эрэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. ВС вирусын шинжилгээнд 112 иргэнийг хамруулснаас шинээр В вирустай 3 иргэнийг илрүүлж вирус тоолуулах шинжилгээнд явуулсан. В вирусын шинжилгээнд хамруулж вирусгүй гарсан 96 хүнийг Гепатит В вирусын эсрэг вакцинд хамруулсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Сумын төвлөрсөн хогийн цэгийг цэгцэлж, талбайн хэмжээг багасгах ажлын тендерийн урилгад тусгах зургийн ажлыг хийлгэхээр Байр зүйн зургийн эрх бүхий компаниудтай холбогдож хамгийн бага үнийн санал ирүүлсэн, ажлын туршлага бүхий “Лэнд луужин” ХХК-д санал тавьж зургийн ажлыг гүйцэтгүүлээ.

Ой хээрийн түймрийн эрсдэл бүхий сумд урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын фэйсбүүк групп, зар мэдээллийн фэйсбүүк группуудад “Ой хээрийн түймрээс сэргийлэх” санамж, мэдээлэл бүхий зөвлөмж, шторк 3 удаа түгээж ажиллаа.

Сумын удирдах ажилтны зөвөлгөөнөөр 2022 оныг Бүтээн байгуулалт, тохижилтын жил болгон зарласантай холбоотойгоор Иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, ААН-үүд өөрийн эзэмшлийн зам талбай, хашаа, гудамжаа цэвэрлэж, хогийн цэгт хаяж хоггүй эрүүл орчинд амьдрахыг уриалж, 2022.03.14-18 нө өдрүүдэд “бүх нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгууллаа. Бүх нийтийн их цэвэрлэгээг хэрхэн зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, тайлан мэдээг нэгтгэн ажиллаа.

Хөдөө аж ахуй: Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд 3 хувийн хүүтэй 2 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын хуралдаанаар баталсантай холбогдуулан тариалан эрхлэгчдийн судалгааг гаргаж ХХААГ-ын газар тариалан хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.

Долоо хоног бүрийн 1 дэх өдөр сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг дэлгүүрүүдээс цуглуулан нэгтгэж, аймгийн ХХААГазрын мэргэжилтэнд хүргүүлж ажиллаж байна.

2022 оны 03 дугаар сарын 22 ны байдлаар 40 зээлдэгчийн 180,06 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 11 зээлдэгчийн 76,650 сая төгрөгийн зээл муу зээлийн ангилалд шилжсэн, эвлэрүүлэн зуучлалын газартай хамтран зээлийн өрийг барагдуулахаар эвлэрлийн гэрээ байгуулан ажиллаж байна. Тухайн сард муу зээлдэгчдээс 3,4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг дансанд төвлөрүүлсэн.

Сар бүр СХС-ийн зээлийн мэдээллийг монгол банканд илгээж, сар бүрийн төлөлтийг дансны хуулагтай тулгаж шивэлтийг хийдэг.

Сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 28 ны өдрийн А/28 тоот захирамжийн дагуу “Малчин зөвлөгөөн-2022” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 05 ны өдөр ЗДТГ, ХХААГ-тай хамтран, Соёлын төвд зохион байгуулж, 6 багийн малчдын төлөөлөл 200 малчин оролцлоо.

Зөвлөгөөний үеэр сумын Засаг дарга 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажил, 2022 онд ХАА-н салбарт цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.

Мөн аймгийн ХХААГ-ийн дарга, мэргэжилтэн, Мал эмнэлгийн газрын Улсын байцаагч, Цагдаагийн тасаг, ЭМГ, Онцгой байдлын газар, ЗЗБУХ төслийн мэргэжилтнүүд оролцож, ХАА-н салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомж бодлого, арга хэмжээ болон малын үржил селекти, үүлдэр, угсаа, эрчимжүүлэлт, малын ангилалт, эзмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлт, хоршоо, бүлэг, мал амьтны эрүүл мэнд, гоц халдварт өвчин, гэмт хэрэг, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, зөв хооллолтын талаар малчдад мэдээлэл хийлээ.

Зөвлөгөөнд хилийн цэргийн 0184-р ангийн үлээвэр хөгжмийн хамтлаг ирж урлагийн тоглолт хийж, үдшийн цэнгүүн зохион байгуулсан.

Засаг даргын тамгын газраас малчдыг дэмжих хүрээнд шагнал урамшуулал гардууллаа. Үүнд: Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор өндөр настан Б.Дуламжав, ХАА-н тэргүүний ажилтан 3, аймгийн Засаг даргын жуух бичиг 1, сумын Засаг даргын жуух бичиг 4, сумын Засаг даргын баярын бичиг 3, Тэргүүний залуу малчин 3, МСУ-ын 25 жилийн ойн медаль 3, Салбарын нэрэмжит тэмдэг 2, Монгол улсын Залуу малчин тэмдэг 7 малчинд тус тус гардуулж, оролцсон малчдын дунд сугалаа зохион байгуулж 6 азтан шалгарууллаа.

Мөн хилийн цэргийн 0184-р анги, Мал эмнэлгийн үржлийн нэгж 5, ААН-ийн төлөөлөл 8, зөвлөгөөнд оролцсон малчдад гарын бэлэг, дурсамж хадгалуулж, Эрүүл мэндийн газар малчдыг ЭХО, рентген харах, В,С вирусийн шинжилгээ, сахар тодорхойлох, дотрын үзлэг, цусны даралт үзэх үйлчилгээ үзүүлсэн.

Малчдын зөвлөгөөнд оролцсон малчид уг зөвлөгөөнийг цаг үеэ олсон үр дүнтэй сайхан зөвлөгөөн болсныг дүгнэж хэлээд “Малыг тооноос чанарт шилжүүлье”, эрчимжсэн мал ахуй эрхлэх, хоршиж хөдөлмөрлөх талаар уриалга гаргасан.

Малчдын зөвлөгөөний арга хэмжээнд захирамжийн дагуу нийт 6,0 сая төгрөгийг зарцуулсан.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн